



“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/01

Улаанбаатар хот

*Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.10 дах заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/01 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА





“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.13 дахь заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА





“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/03

Улаанбаатар хот

*Гадаад валютын арилжаа эрхлэхтэй холбоотой
Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлах*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 19 тоот тогтоол болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/03 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компани гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөл нэмж хүсэхтэй холбоотойгоор Компанийн дүрмийн 3.1 дэх хэсэгт үйл ажиллагааны чиглэл нэмсэн дүрмийн төслийг Хавсралт 1-р баталсугай.
2. Санхүүгийн зохицуулах хорооноос гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөл олгосон нөхцөлд Компанийн дүрмийн төслийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА





“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/04

Улаанбаатар хот

Компанийн “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” батлах

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 24 тоот болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/04 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийг энэхүү тогтоолын Хавсралт 1-р баталсугай.
2. “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Компани хувьцаа халааслах, халаасны хувьцааг эргэлтэнд гаргах болон шинээр үнэт цаас гаргах нөхцөлд компанийн хувьцаа эзэмшигч нь үнэт цаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороо болон Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА





“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/05

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт батлах

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/05 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын Хавсралт 1-р баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

